



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/04

Мандалговь

Г Эзэмшил газрын нэр өөрчлөх тухай Г

Монгол улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Г.Чагдаржавын гудамж-1-122) байршилтай Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 4 дүгээр сургуулийн нэр нь өөрчлөгдөж Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын "Цэгц билиг" сургууль нэртэй болсон тул газрын гэрчилгээг шинэчлэн эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрхи байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/130 дугаар захирамжийн Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 4 дүгээр сургуульд холбогдох хэсэг, Мөн газар эзэмших 000433318 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010013